



**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ**

Засгийн газрын байр 12, Барилгачдын талбай 3,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 61 71, Цахим шуудан: contact@met.gov.mn,
Цахим хуудас: www.mecc.gov.mn

2025. 01.10 № 02/131

танай _____-ны № _____-т

**ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Т.ЭНХБАЯР ТАНАА**

Танай 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 294 дугаартай албан бичигтэй танилцаад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Цаг уур, орчны шинжилгээний газар, Усны газар, Ойн газрын тайлан, мэдээллийг нэгтгэн хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ¹¹ хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Э БАТТУЛГА

902407

CE 25822

1525000232

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны
Төрийн нарийн бичгийн даргын
2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн
02/131 дугаартай албан бичгийн хавсралт

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР САЛБАРТ БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙГДСЭН ТАЙЛАН

9024

4 СЕТ-25822

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар)	Салбар зөвлөлийн өөрийн үнэлгээ
				Он	Түвшин			
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЗОРИЛГО:ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САЛБАР ДУНДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 5								
5.1.1	Ногоон хөгжлийн бодлогыг бүх бодлогын суурь болгон жендэрийн мэдрэмжтэй хөгжүүлнэ.	0	Жендэрийн мэдрэмжтэй ногоон зорилтот хөтөлбөр	2024	0	1	Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг холбогдох яам, агентлагийн саналыг тусган боловсруулж Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны А/232 дугаар тушаалаар батлуулж, Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагад хүргүүлсэн. Тус төлөвлөгөөний 4-р зорилт "Ногоон ажил эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ"-д 4.1. зохистой хөдөлмөр эрхлэлт, орлогын баталгаатай эх үүсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлэх, 4.2. Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг сайжруулж аюулгүй байдлыг хангах, эрүүл аж төрөхөд шаардлагатай нийгмийн үйлчилгээг тэгш хүртээх боломжийг бүрдүүлэх, 4.3. Байгалийн хүчин зүйл, баялгаас шууд хамаарал бүхий иргэдийн амьжиргааг сайжруулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг даван туулах чадавхыг бэхжүүлэх зэрэг Жендертэй хобоотой ажлууд тусгасан байна.	


5.1.3	Хүлэмжийн хийн үндсэн ялгаруулагч мал аж ахуй, эрчим хүч, уул уурхайн салбарын үйлдвэрлэлд жендэрийн хүчин зүйлс, үр нөлөөний шинжилгээ хийж, холбогдох бодлогын баримт бичигт тусгана.	Төсөл хөтөлбөр	Бодлогын баримт бичгийн өөрчлөлт хийгдсэн эсэх	2024	Үгүй	Тийм	Жендэр болон орхигдсон бүлэгт төвлөрсөн үндэсний хэмжээний эмзэг байдлын үнэлгээ хийх энэхүү зөвлөх үйлчилгээг Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Нэгдсэн үндэсний байгууллагын Байгаль орчны хөтөлбөрөөс Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгох үндэсний чадавх бэхжүүлэх" төслийн хүрээнд хийж гүйцэтгэн Үндэсний дасан зохицолын төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээг тусгасан.
5.1.4	Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол ба жендэрийн асуудлын харилцан уялдааг тодорхойлох судалгааг мал аж ахуй, уул уурхайн зэрэг салбарт хийж, зөвлөмж гаргаж хэрэгжүүлнэ.	Төсөл хөтөлбөр	Зөвлөмж хэрэгжүүлсэн салбар	2024	0		Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь (АДАПТ төсөл): Төсөл хэрэгжих аймгуудад уур амьсгалын өөрчлөлт, жендерийн тэгш байдлын талаарх малчдын мэдлэгийг дээшлүүлж, гамшгийн үеийн малчин эмэгтэйчүүдийн хэрэгцээг тодорхойлох 50,000 ам.долларын төсөв бүхий үйл ажиллагааг төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, ажлын даалгаврыг боловсруулан, батлуулав. Зөвлөх үйлчилгээний тендэрийг нээлттэй зарласан.
5.1.6	Байгаль орчны салбарын бодлого, үнэлгээнд жендэрийн шалгуур үзүүлэлт нэвтрүүлнэ.	0	Шалгуур үзүүлэлт нэвтэрсэн эсэх	2024	Үгүй	Тийм	Уур амьсгалын Үндэсний хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөө"-нд жендерийн асуудлыг анхаарч тусган батлуулсан. Дурдвал: Арга хэмжээ 2.7. Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өртөмтгий нийгмийн бүлгүүдийг тодорхойлж, тэдгээрийн амьжиргаанд гарч буй өөрчлөлтөд жендэрийн дүн шинжилгээ, судалгаа хийх Арга хэмжээ 14.1. Нийгмийн эрүүл мэндийг уур амьсгалын өөрчлөлтийн улмаас

							үүдэлтэй өвчлөл, эндэгдлээс хамгаалах нотолгоонд тулгуурласан, жендэрийн мэдрэмжтэй зөвлөмж боловсруулах	
5.2.4	Жендэрийн тэгш оролцоог хангасан ногоон ажлын байрыг бий болгох хүрээнд сайн туршлагыг салбаруудад гаргаж түгээнэ.	Төсөл хөтөлбөр	Сайн туршлага, салбараар	2024	0	5	БОАЖЯ, Азийн Хөгжлийн Банк, Монголын тогтвортой санхүүгийн холбоо, "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран хэрэгжүүлж буй "Тойрог эдийн засаг ба ногоон бизнесийн чиглэлд бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах зөвлөх үйлчилгээ"-ний хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар, Хөвсгөл, Архангай аймгуудад цуврал сургалтууд болон ганцаарчилсан менторын зөвлөгөөг амжилттай зохион байгуулж, нийт 420 эмэгтэй бизнес эрхлэгчид хамруулснаас 15 эмэгтэй бизнес эрхлэгчийг сонгон шалгаруулан, тус бүрт нь 10,000 ам.доллар хүртэлх тэтгэлэг олгож, Нэгдүгээр байрт шалгарсан "Бортот Хүүн" ХХК Хонгконгт туршлага судлах аялалд амжилттай оролцсон болно.	
5.2.5	Байгаль орчинд ээлтэй зохистой үйлдвэрлэлийн шинэ стандарт, зохистой хэрэглээний дадлыг нэвтрүүлэхэд аж ахуй эрхлэгчдийн мэргэжлийн холбоод, эмэгтэйчүүд, жендэрийн чиглэлээр ажилладаг ТББ, хэвлэл мэдээллийн хамтын ажиллагааг хөгжүүлнэ.	Төсөл хөтөлбөр	Арга хэмжээ	2024	0	5	"Тойрог эдийн засаг ба ногоон бизнесийн чиглэлд бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах зөвлөх үйлчилгээ"-ний хөтөлбөрийн хүрээнд Эрчим хүч хэмнэлтийн менежментийн чиглэлээр 3, Хүнсний болон бусад хог хаягдлын менежментийн чиглэлээр 5, Усны хэрэглээг багасгах, дахин ашиглалтыг дэмжих, усыг дахин боловсруулах чиглэлээр 1, Байгаль орчинд ээлтэй хүнс, хоол үйлдвэрлэлийн сав баглаа боодол болон түүний материалын чиглэлээр 3, Байгаль орчинд ээлтэй ариун цэврийн байгууламжийн чиглэлээр 3, нийт 15 эмэгтэй бизнес эрхлэгчийн үйл ажиллагаанд Байгаль орчинд ээлтэй зохистой үйлдвэрлэлийн шинэ стандарт, зохистой хэрэглээний дадлыг нэвтрүүлэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.	
5.3.2	Бүсийн онцлогт нийцсэн газар тариалан, аялал	Төсөл хөтөлбөр	Сайн туршлага, салбараар	2024	0	5	БОАЖЯ, Азийн Хөгжлийн Банк, Монголын тогтвортой санхүүгийн холбоо, "Хөгжлийн	

	жуулчлал зэрэг эмэгтэй хэв шинжийн ногоон аж ахуйн сайн туршлага илрүүлж, түгээн дэлгэрүүлнэ.						шийдэл" ТББ-тай хамтран хэрэгжүүлж буй "Тойрог эдийн засаг ба ногоон бизнесийн чиглэлд бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах зөвлөх үйлчилгээ"-ний хөтөлбөрийн хүрээнд Аялал жуулчлалын салбар дахь хоол, хүнс болон сав, баглаа боодолын чиглэлээр хоол, шингэн хүнсний үйлчилгээ үзүүлэгчид, байгалийн, соёлын арга хэмжээ зохион байгуулагчид, аялал жуулчлалын баазууд, зам дагуух үйлчилгээ үзүүлэгчид, сав баглаа боодол нийлүүлэгчид, чөлөөт цаг өнгөрөөх, тусгайлсан үйлчилгээ эрхлэгчдээс хамгийн шилдэг бизнес төслийн санал гаргасан 15 эмэгтэй бизнес эрхлэгчийг сонгон шалгаруулан, тус бүрт нь 10,000 ам.доллар хүртэлх тэтгэлэг олгосон.	
5.3.3	Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицоход хөдөөгийн эмэгтэйчүүд охидын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх технологи дамжуулахад олон улсын түвшинд хамтарч ажиллана.	0	Нэвтрүүлсэн техник технологи	2024	0	1	НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 78 дугаар чуулганы хуралдаанаар Монгол Улс нь "Хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах тухай" тогтоолыг санаачлан батлуулсан нь энэ хүрээнд онцгой анхаарал хандуулан ажиллаж байгааг илтгэж байгаа юм.	
5.3.4	Байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр эмэгтэйчүүдийн чадавхыг бэхжүүлэх зөвлөх үйлчилгээг нэвтрүүлнэ.	Төсөл хөтөлбөр	Зөвлөх үйлчилгээний төрөл	2024	1	4	БОАЖЯ, Азийн Хөгжлийн Банк, Монголын тогтвортой санхүүгийн холбоо, "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран хэрэгжүүлж буй "Тойрог эдийн засаг ба ногоон бизнесийн чиглэлд бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах зөвлөх үйлчилгээ"-ний хөтөлбөрийн хүрээнд Аялал жуулчлалын салбар дахь хоол, хүнс болон сав, баглаа боодолын чиглэлээр хоол, шингэн хүнсний үйлчилгээ үзүүлэгчид, байгалийн, соёлын арга хэмжээ зохион байгуулагчид, аялал жуулчлалын баазууд, зам дагуух үйлчилгээ үзүүлэгчид, сав баглаа боодол нийлүүлэгчид, чөлөөт цаг өнгөрөөх, тусгайлсан үйлчилгээ эрхлэгчдээс хамгийн	

							шилдэг бизнес төслийн санал гаргасан 15 эмэгтэй бизнес эрхлэгчийг сонгон шалгаруулан, тус бүрт нь 10,000 ам.доллар хүртэлх тэтгэлэг олгосон.
5.3.5	Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн үйл ажиллагааг жөндөрийн тэгш оролцоогоор дэмжих сайн туршлага гаргаж түгээн дэлгэрүүлнэ.	Төсөл хөтөлбөр	Сайн туршлага	2024	0	5	Хэнтий аймгийн Норовлин сумын Онон багийн БНХМ-ийн Хөндлөн нөхөрлөл нь 14 өрх айл хамтарсан нөхөрлөл юм. Энэ нөхөрлөлийнхөн гишүүд эмэгтэйчүүдийн идэвхи санаачлагаар 2021 онд анх зөгийн аж ахуй эрхлэхээр жижиг төсөл боловсруулж маш цөөхөн бүл зөгий авч ажиллаж эхэлсэн байдаг. Улмаар тууштай тогтвортой хүчин чармайлт гаргаж ажилласны дүнд өдгөө 20-30 бүл зөгийтэй болж нийт эрэгтэй эмэгтэй гишүүдийн тэгш оролцоог хангаж ажилладаг. Улмаар зөгийн аж ахуйгаас гарч буй бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулж дундын сангаа хуримтлуулж байгал хамгааллын төлөвлөгөөгөө шийдэж хэрэгжүүлж байна. Улмаар 2024 оноос Байгалийн үзэсгэлэнт газраа түшиглэж гишүүдийн тэгш оролцоотой эко аялал жуулчлал, кэмп ажиллуулахаар санаачлан ажиллаж байгаа.

Тайлан хянасан:
Төрийн захиргааны удирдлагын
газрын дарга



Д.Дэлгэрбат

Тайлан нэгтгэсэн:
Өргөдөл, гомдол, жөндөр, гамшиг,
дайчилгаа хариуцсан ахлах
зохион байгуулагчиг



С.Батзориг

2025 оны 01 сарын 12 өдөр

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БОЛОН ХАРЬЯА БУСАД БАЙГУУЛЛАГАД
АЖИЛЛАЖ БУЙ АЛБАН ХААГЧДЫН 2024 ОНЫ МЭДЭЭ**

МАЯГТ-1: Төрийн захиргааны төв болон харьяа бусад байгууллагад ажиллагчдын хүйсийн тэнцвэрт байдлын 2024 оны мэдээ

МАЯГТ-1а:

№	Төрийн захиргааны төв байгууллага болон түүний харьяа агентлагийн нэр	Нийт төрийн албан хаагчид (үндсэн)	
		эрэгтэй	эмэгтэй
1.	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	47	60
2.	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар	21	15
3.	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газар	18	47
4.	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар	13	21
	Нийт	99	143

МАЯГТ-1б:

№	Төрийн захиргааны төв байгууллагын нэр	Нийт улс төрийн албан хаагч		Үүнээс			
		эр	эм	Сайд		Гүйцэтгэх, туслах	
				эр	эм	эр	эм
1.	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	3	2	-	1	1	3

МАЯГТ-1в

№	Төрийн захиргааны төв байгууллага болон түүний харьяа агентлаг	Нийт төрийн захиргааны АХ		Үүнээс					
		эр	эм	Төрийн нарийн бичгийн дарга/Агентлагийн дарга		Газар, хэлтсийн дарга		Бусад гүйцэтгэх, туслах	
				эр	эм	эр	эм	эр	эм
1.	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	38	46	1	-	11	8	26	38
2.	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар	17	11	1	-	3	-	13	11
3.	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур,	4	17	-	1	3	2	1	14

	орчны шинжилгээний газар								
4.	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар	-	-	1	-	2	2	7	15
	Нийт	59	74	3	1	19	12	47	78

МАЯГТ-1г

№	Төрийн захиргааны төв болон харьяа агентлаг	Нийт төрийн тусгай АХ		Үүнээс					
		эр	эм	Төрийн нарийн бичгийн дарга/Агентлагийн дарга		Газар, хэлтсийн дарга		Бусад гүйцэтгэх, туслах	
				эр	эм	эр	эм	эр	эм
1.	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	-	-	-	-	-	-	-	-
2.	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар	-	-	-	-	-	-	-	-
3.	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газар	-	-	-	-	-	-	-	-
4.	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар	-	-	-	-	-	-	-	-

МАЯГТ-1д

№	Төрийн захиргааны төв болон харьяа бусад байгууллагын нэр	Нийт төрийн үйлчилгээний АХ		Үүнээс					
		эр	эм	Агентлагийн дарга		Газар, хэлтсийн дарга		Бусад гүйцэтгэх, туслах	
				эр	эм	эр	эм	эр	эм
1.	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	6	12	-	-	-	-	-	-
2.	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар	3	5	-	-	-	-	3	5

3.	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газар	14	30	-	-	-	-	14	30
4.	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар	3	4	-	-	-	-	3	4
	Нийт	26	51	0	0	0	0	20	39

МАЯГТ-2: Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон бусад харьяа агентлагийн дэргэдэх хороо, зөвлөл, комиссын бүрэлдэхүүний хүйсийн тэнцвэрт байдлын 2024 оны мэдээ

№	Хороо, зөвлөл, комиссын нэр	Байгуулсан шийдвэрийн нэр, дугаар, огноо	Нийт дарга, гишүүдийн тоо	Дарга		Гишүүд	
				эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй
1.	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо	МУЗГ-ын 2024.12.18-ны 211 дүгээр тогтоол	23	1	1	21	-
2.	Төрийн албаны салбар зөвлөл	ТАЗ-ийн 2024.08.07-ны 334 дүгээр тогтоол	7	1	-	2	4
	Нийт дүн		30	2	1	23	4

Тайлан хянасан:

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Дэлгэрбат

.....(Гарын үсэг)

Тайлан нэгтгэсэн:

Өргөдөл, гомдол, жендэр, гамшиг, дайчилгаа хариуцсан ахлах зохион байгуулагчиг С.Батзориг

.....(Гарын үсэг)

2025 оны 01 сарын 10 өдөр

Жендэрийн салбар зөвлөл (дэд зөвлөл)-ийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчилэн батласан тухай холбогдох шийдвэр

№	Яам, агентлагийн нэр	Шинэчлэн батлагдсан журмын огноо	Бүрэлдэхүүний тоо
1	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар	2023.10.09 А/214	7

Жендэрийн үндэсний хорооны 2024 оны тогтоол шийдвэрийн хэрэгжилт

№	Тогтоолын дугаар/огноо	Тогтоолын тэргүү	Тогтоолын агуулга	Хэрэгжилт(бүтэн жилээр)
1.	2 2024-02-15	Чиглэл өгөх тухай	<p>1.1.Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтыг зөрүүг багасгах чиглэлээр дараагийн шатны тусгайлсан төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг жендэрийн салбар зөвлөлийн дарга, хорооны гишүүдэд:</p> <p>1.4.Боловсролын ерөнхий хууль, Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулга энэ оноос хэрэгжиж байгаатай холбогдуулан бүх нийтийн жендэрийн болон эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлэд анхаарч ажиллахыг Хорооны гишүүдэд тус тус даалгасугай.</p>	<p>ЖҮХ-с “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)”-г танилцуулах ажлыг 2024.11.23-ны өдөр БОУАӨЯаманд хийсэн. Уг танилцуулга сургалтанд яам, салбар байгууллагуудын албан хаагчид хамрагдсан.</p> <p>Албан хаагчдын эрүүл мэндэд анхаарч, ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт үед нь илрүүлж, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийг хамгаалах зорилтын хүрээнд “Супернова” Япон улсын жишиг эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 13-с үзлэг, шинжилгээ эхэлнэ.</p>

Тайлан хянасан:

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Дэлгэрбат

.....(Гарын үсэг)

Тайлан нэгтгэсэн:

Өргөдөл, гомдол, жендэр, гамшиг, дайчилгаа хариуцсан ахлах зохион байгуулагчиг С.Батзориг

.....(Гарын үсэг)

2025 оны 01 сарын 10 өдөр

**“Удирдах албан тушаалтанд зориулсан жендэрийн цахим сургалт”-д
хамрагдсан удирдах албан хаагчдын мэдээлэл**

№	Яам, агентлагийн нэр	Овог, нэр, албан тушаал	Хүйс	Гэрчилгээний дугаар
1	БОУАӨЯ	С.Батзориг, өргөдөл, гомдол, жендэр, гамшиг, дайчилгаа хариуцсан ахлах зохион байгуулагч	Эр	2024-190
2	Ойн газар	Д.Гантулга-Захиргаа удирдлагын хэлтсийн дарга	Эр	-
3	Усны газар	Гэрэлчулуун Ичинхорлоо	Эм	-

**“Иргэд, олон нийтэд зориулсан жендэрийн цахим тест”-д
хамрагдсан албан хаагчдын мэдээлэл**

№	Яам, агентлагийн нэр	Овог, нэр, албан тушаал	Хүйс
1	Ойн газар	С.Нарантуяа-Тэрбум мод хөдөлгөөний хэрэгжилт, мониторинг хариуцсан ахлах мэргэжилтэн	Эм
2	Ойн газар	П.Уянга-Төслийн ажилтан	Эм
3	Ойн газар	Б.Гандолгор-Төслийн ажилтан	Эм
4	Ойн газар	Г.Энхжин- Төслийн ажилтан	Эм
5	Цаг уур орчны шинжилгээний газар	Захиргаа аудитын хэлтсийн дарга Р.Бадмаадорж	Эм
6	Цаг уур орчны шинжилгээний газар	Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн Ж.Энхчимэг	Эм
7	Цаг уур орчны шинжилгээний газар	Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, тайлан хариуцсан ахлах мэргэжилтэн М.Лхагвасүрэн	Эм
8	Цаг уур орчны шинжилгээний газар	Санхүүгийн дотоод аудитор Б.Баасансүрэн	Эм
9	Цаг уур орчны шинжилгээний газар	Цаг уурын ажиглалт, хэмжлийн технологийн хяналт, шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн С.Наранчимэг	Эм
10	Цаг уур орчны шинжилгээний газар	Байгууллагын архив хариуцсан мэргэжилтэн Х.Туулцэцэг	Эм
11	Цаг уур орчны шинжилгээний газар	Шагнал, жендэр хариуцсан мэргэжилтэн Б.Мягмаржав	Эм
12	Цаг уур орчны шинжилгээний газар	Ахлах нягтлан бодогч Д.Отгонбаяр	Эм
13	Цаг уур орчны шинжилгээний газар	Тооцооны нягтлан бодогч С.Цэрэннадмид	Эм
14	Цаг уур орчны шинжилгээний газар	Касс, эд ахуйн нярав О.Оюунцэцэг	Эм

15	Цаг уур орчны шинжилгээний газар	Гадаад харилцааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Ц.Мөнхзаяа	Эм
16	Цаг уур орчны шинжилгээний газар	Гадаад харицааны асуудал хариуцсан мэргэжилтэн А.Солонго	Эм
17	Цаг уур орчны шинжилгээний газар	Хөрөнгө оруулалт, өмч ашиглалт хариуцсан мэргэжилтэн Г.Болорсүх	Эм
18	Цаг уур орчны шинжилгээний газар	Архив, мэдээллийн сангийн удирдлагын системийн ерөнхий инженер М.Хишигжаргал	Эм
19	Цаг уур орчны шинжилгээний газар	Мэдээллийн үйлчилгээ хариуцсан инженер Т.Туяа	Эм

Жич: Яамны болон агентлагуудын албаны дотоод сүлжээгээр дээрх сургалтын зарыг түгээсэн.

Сургалтанд хамрагдсан албан хаагчдын мэдээллийг цахим сургалтын платформын админаас гаргах боломжтой.